

ҮНДСЭН ХУУЛИЙН ХӨГЖЛИЙГ ШИНЭ ХАНДЛАГААР СУДЛАХ НЬ

Б.Баярсайхан

*Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад
суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд,
хууль зүйн доктор*

Оршил

Б.Чимид багш (цаашид “зохиогч” гэх)-ийн “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” бүтээлийн “Үндсэн хуулийн хөгжлийг шинэ хандлагаар судлах нь” нэгдүгээр бүлгийн “Судалгааны арга зүй, гол хандлагыг шинэтгэх нь”, “Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжлийг үечлэх нь”, “Социалист маягийн Үндсэн хуулийн тухай”, “1992 оны Үндсэн хууль бол шинэ маягийн Үндсэн хууль” гэсэн дөрвөн дэд бүлэгт дүн шинжилгээ хийх нь сүрдмээр, хувьд хүнд ахадсан, маш хүнд даалгавар байсныг тэмдэглэн алдаа, оноотой байх аваас өршөөн хэлтрүүлэхийг хүсье.

Багшийн бүтээлүүд нь утга, агуулга гүн гүнзгий, өгүүлбэр бүрийн утга санааны чандыг ухаарах нь уншигч, судлаачдаас өргөн мэдлэг, хүч хөдөлмөр, хичээл зүтгэл шаардах нь эргэлзээгүй тул энэ удаад Үндсэн хуулийн цэцээс анх удаа бүтээлийн уншлага буюу критик анализ хийх санал санаачилгыг талархан хүлээн авч, салбарын шинжлэх ухааны бүтээлч санаачилгад нэгдэх боломж олгосон зохион байгуулагчдад талархал илэрхийлж байна.

Юуны өмнө зохиогч бүтээлээ “Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил” гэж тодотгон” Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” гэж яагаад нэрлэх болсон бэ? гэх асуултыг хэн бүхэнд тавих биз ээ.

Үүнд хариулахын тулд зохиогчийн “Үндсэн хууль бол алганд багтсан Монгол Улс” гэсэн хэлц үгийг онцлох нь зүйтэй юм. Үндсэн хууль нь Монгол Улс оршин тогтнох язгуур “концепц”-ын бодит тусгал төдийгүй хүн бүр утга, агуулгыг ойлгон, ухаарах ёстойг учирласан болохыг бүтээлийн үг, өгүүлбэрт бүрт шингээсэн өчил гэж ойлгож байна.

Цаашилбал, бүтээлийн нэгдүгээр бүлгийн үндсэн агуулга нь Монгол Улсын Үндсэн хуульт ёсны хөгжлийг бүрэн хамарсан бөгөөд ингэхдээ бичилтийн хэлбэрийн хувьд академик төдийгүй “хүнд бүрт хандсан” энгийн бичилтийг хосолсон төдийгүй эрх зүйн шинжлэх ухааны бэрхшээлтэй тулгуур ойлголтуудыг дараа дараагийн бүлгүүдэд “Хувьсгалаар уу?, хувьслаар уу?”, “Чихээр сонссоны хувьд юу хэлж болох вэ?”, “Хураангуйлах”-ын учир юусан билээ?” гэх зэргээр бусдын анхаарлыг татахуйц энгийнээр хүүрнэн өгүүлсэн, учирласан хэлбэрийг сонгосон нь бүтээлийн амин сүнслэг чанар оршино.

Зохиогч бүтээлдээ хэрэглэсэн нэр томьёо, үг, цэг, таслал бүрийг уншигчдад ойлгомжтой, санаж сэрэхэд хялбар байдлаар сонгосон нь эрх зүйн шинжлэх ухааны бүтээлд тогтсон хэвшмэл хэв хэллэгийг эвдсэн төдийгүй мэргэшсэн судлаачдад төдийгүй сонирхсон хэн бүхэнд бүтээлийн утга санааг хүргэх зорилго агуулсны илэрхийлэл гэдэгтэй санал нийлэх буй за.

Багшийн бүтээлүүдийг уншихад “аугаа бүхэн энгийн” гэх хэлц үгийн бодит үлгэрийг мэдрүүлэх болно.

Товчлол

- Үндсэн хуулийн хөгжлийг шинэ хандлагаар судлахад “судалгааны арга зүй, гол хандлагыг шинэтгэх нь” нийгмийн хэрэгцээ шаардлага хэдийнээ болсныг 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш өрнөж буй улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явцын өрнөл, мөн уг хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй эерэг, сөрөг нөлөөлөл зэргийг Үндсэн хуулийн уламжлал, шинэчлэлийн харилцан хамаарлыг шинжилжээ.

- Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжилд 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд нь хэдийгээр “Социалист маягийн Үндсэн хууль” гэж зохиогч нэгтгэн авч үзсэн боловч 1924 оны Үндсэн хуулийг тусгайлан “Анхны Үндсэн хуулийг онцлон үзэхийн учир” хэмээн онцолсныг анзаарахгүй өнгөрөх учиргүй. Мөн 1940, 1960 оны Үндсэн хуулийн тухай зохиогч хэдэн санааг онцлохдоо тэдгээр Үндсэн хуулиудын агуулгын зөрөөгүй байдлыг эх сурвалжийн түвшинд судалсан юм.

- Зохиогч бүтээлийн энэ хэсэгт 1992 оны Үндсэн хуулийг боловсруулахдаа олон улсын жишиг хандлага, үндэсний эрх зүйн хөгжлийн харилцан хамаарал, нийгмийн шилжилтийн үе дэх Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт, уг зохицуулалтын нийгэм, улс төр, эдийн засгийн байгуулалтад хэрхэн нөлөөлсөн зэрэг асуудлыг хөндсөн нь энэ чиглэлээр туурвисан бүтээлүүдээс онцлог юм.

Дүн шинжилгээ

Нэг. Бүтээлийн нэгдүгээр бүлэг нь бусад бүлгүүдийн онол, арга зүйн үндэс болсон төдийгүй бүлэг тус бүрт уламжлал шинэчлэлийн харилцан хамааралд нь авч үзсэнээрээ “Үндсэн хуулийг тогтвортой баримтлах” ёс, эрх зүйн ухамсар бодитоор төлөвшиж, “Улс орон тогтвортой хөгжих үндэс нь” дарга тогтвортой

байхад бус”, харин хууль тогтвортой “даргалахад” оршдогийг амьдрал хэдийнээ харуулсан ...” гэж “хууль засаглах учиртай” онолын үндсийг тэмдэглэсэн. Зохиогчийн энэхүү дүгнэлт түүхийн философи-оор тайлбарлагдах учиртай.

Зохиогчийн энэ хэсэгт цухасхан ч томоохон асуудлыг хөндсөн. Энэ нь Монгол Улсын эрх зүйн шинжлэх ухааны хувь заяаны асуудал байлаа.

Тэрээр “Монголын нийгэмд шинэтгэл хийж эхэлсэн 1990-ээд оноос хойшхи цөөн жилд нийгмийн ухамсар, тэр дундаа эрх зүйн ухамсар, эрх зүйн соёл, зөн совинд гэхээсээ илүү туршлагад үндэслэсэн шинжлэх ухааны сэтгэлгээ эрхбиш шинэчлэгдсээр буй нь ойлгомжтой.”¹ гэснийг задлан шинжилж нэгийг бодон хоёрыг ухаарах цаг болсон гэж сэтгэнэ.

Зохиогч энэхүү дүгнэлтийг “судалгааны онол, арга зүйн хандлагыг шинэтгэх нь” хэсэгт “туршлагад үндэслэсэн шинжлэх ухааны сэтгэлгээ эрхбиш шинэчлэгдсээр буй нь ойлгомжтой” гэсэнд олон зүйлийн учиг, зангилаа буй гэдэгт эргэлзэхгүй байна.

Хоёр. Уг дэд бүлэгт 1990 оны нийгэм, улс төрийн үйл явц шинэ Үндсэн хууль боловсруулах зайлшгүй шаардлагыг нөхцөлдүүлснийг авч үзсэний зэрэгцээ 2006 оныг хүртэл буюу шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш 14 жилийн хугацаанд “Үндсэн хуулийг судлах арга зүй, хандлага”-ыг нэг талаас хэрхэн авч үзэх, нөгөө талаас шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш хугацаанд хийгдсэн эрх зүйн судалгаанд шинжилгээ хийснээ дараах байдлаар илэрхийлсэн:

- “Зарчмын эрс өөрчлөлт нь төр, эрх зүйн үзэгдлийг намч, ангич, үзэл сурталч байр сууриас ангид онолын шинэ хандлага, арга зүй, аргаар шинжлэн судлах зайлшгүй

¹ Бүтээлийн 11 дэх тал.

шаардлагыг төрүүлэв. Энэ нь Үндсэн хуулийн хэв маяг, мөн чанар, үүрэг, ач холбогдлыг үнэн зөвөөр үнэлж, бодит дүгнэлт хийж, сургамж авахын анхдагч нөхцөл болно” гэдгийг;

- “1992 оноос хойш манай оронд Төрийн буюу Үндсэн хуулийн эрх зүйн ном зохиол элбэгшсэн нь талархан дэмжүүштэй үйлс мөн. Шинэ Үндсэн хуульд тулгуурласан ном зохиолд шинэ соргог санаа байлгүй яах вэ. Харин Монгол Улс Үндсэн хуульт байгуулалд шилжин орж, оршин хөгжсөн үйл явц, үр дагаврыг өмнөх, хойнохтой нь жишин шинжих, бүхэлд нь судлах шинжлэх ухааны арга зүй, арга, хандлага нь хэр шинэчлэгдэж вэ? гэдэгт сэтгэл ханах хараахан болоогүй мэт.” гэдгийг;

- “бид шинжлэл судлалынхаа хуучин хандлага, аргаас төдий л зоригтой салж, олигтой холдож чадаагүй, айдас хүйдсээс ч бас бүрэн ангижраагүй, өнгөрснөө давтсаар байгаагаа нуухын хэрэг огт үгүй. “Даравч дардайна, булавч бултайна”” гэдгийг;

- “Үндсэн хуулиуд, тэдгээрт холбогдох актыг тухайн үеийн амьдралтай холбож түүхчлэн, харьцуулан судалж учир шалтгааны дүгнэлт хийх нь төдий л ажиглагдахгүй байна. Түүнчлэн дэлхийн бусад орны ижилсэх, ондоосох үзэгдэл юмстай харьцуулан харгалзах буюу баримжаалахын оронд бүх юм цоо шинээр гэнэт гарч ирсэн юм шиг, эсхүл дэлхийн улсуудад байгаа бүхэн нь Монголд яг тохирох хосгүй хувилбар мэт өнгөц салхилж, дээгүүр шуурах, түүхэн үзэгдлийг зөвхөн эдүгээчлэх, хий хоосон орон зай байсан мэт үгүйсгэх зэрэг хандлага үзэгдсээр буйг тэвчихэд бэрх.”² гэжээ.

² Бүтээлийн 11 дэх тал.

- Зохигч “анхдагч нөхцөл”, “сэтгэл ханах хараахан болоогүй мэт”, “эдүгээчлэх, хий хоосон орон зай байсан мэт үгүйсгэх зэрэг хандлага үзэгдсээр буйг тэвчихэд бэрх”, “учир шалтгааны дүгнэлт хийх нь төдий л ажиглагдахгүй байна” гэж тус тус тодотгон суурь судалгаа хийх улс төрийн болон үзэл санааны цензур арилсан хэдий ч судалгаа хангалтгүй байгааг хатуухан боловч үнэнийг Та бидэнд сануулсан. Зохиогчийн энэхүү сэтгэл зовнил эдүгээ ч арилаагүй гэдэгт санал нийлнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Мөн “дэлхийн улсуудад байгаа бүхэн нь Монголд яг тохирох хосгүй хувилбар мэт өнгөц салхилж, дээгүүр шуурах, түүхэн үзэгдлийг зөвхөн эдүгээчлэх, хий хоосон орон зай байсан мэт үгүйсгэх зэрэг хандлага үзэгдсээр” буйд өөртөө төдийгүй эрхэм эрх зүй судлаачид дүгнэлт хийх цаг болсон. Энэхүү үзэгдэл нь эцсийн дүнд үндэсний эрх зүйн шинжлэх ухааны тогтолцоо, бодлоготой холбоотойгоор бусдад зоолох боломжийг олгож буй хэрэг.

Гурав. Үндсэн хуулийн хөгжлийн зүй тогтлыг ажиглан үечлэхдээ “дэлхийн улсуудын хуулийн төрөл буюу хэв маягийг харгалзан мөн чанарыг гол шалгуур болгон баримтлах”³ үндэслэлийг онол, үзэл баримтлалын түвшинд гаргаж тавьсан юм.

Ингэхдээ эл асуудалд хандаж буй нөхцөл байдлыг дараах байдлаар томъёолсон:

- “Сүүлийн жилүүдэд (1992 оноос хойш) гарч буй бүтээлүүдээс үзэхэд Үндсэн хуулийн хөгжлийг түүхчлэн үзлээ гэхдээ л их бодож батлагдсан оноор нь үечлэх, өчнөөн төчнөөн бүлэг зүйлтэй гэхчлэн зөвхөн бүтцээр хучиж мөн чанарыг бүрхэгдүүлэх, онолын ултай дүгнэлт хийхийн оронд хуулиа хуулбарлан хуудас зузааруулахаас нэг их хэтрэхгүй байна. Энэ бол бидний сүрхий доголдол мөн.” гэдгийг;

³ Бүтээлийн 13 дахь тал.

- “Ер нь хэлбэрдэж, хялбарчлаад үзэл баримтлал, мөн чанар, гүйцэтгэсэн чиг үүрэг зэрэг агуулгын чанартай шалгуурыг баримтлан Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны ангилал хийж, дүгнэлт өгөхөөс зайлсхийгээд байх шиг”⁴ гэж зохиогч өөрийн эмзэглэлийг гашуун ч гэсэн шар тос болох сургамжийг өгүүлсэн.

Дээрх дурдсан гажуудлыг засахад зохиогч дараах асуудлыг авч үзсэн юм. Үүнд:

- “он цагийн тоон үзүүлэлтээр биш, онцгой ач холбогдлыг нь илэрхийлэх шалгуураар ангилах нь илүү унацтай байхсан” гээд Үндсэн хуулийг агуулгын хувьд “ардчилсан бус”, “ардчилсан” гэж ангилах онол арга зүйн үндсийг тавьсан.

Мөн эдүгээ, он цагийг шалгуур болгон үечлэх асуудлын эерэг болон сөрөг талуудыг “Монголын 4 удаагийн үндсэн, 1 удаагийн нэмэлтийн хуулийг энэ мэт шалгуураар биш, зөвхөн батлагдсан он дарааллаар “үечлээд” түүний хөгжлийг 1924-1940; 1940-1960; 1960-1992 оны; 1992 оноос өдгөө гэсэн дөрвөн үед хуваадаг зуршил тогтжээ. Он дарааллыг баримтлах нь хамгийн хялбар, маргашгүй мэт боловч нэгэнт өнгөрөн төгссөн цаг, түүхэн үйл явцын гадна талыг буюу бүрхүүлийг нь харуулснаас биш, “арьсан доорхи” гүнд орж мөн чанар, олон талын ач холбогдол, оноо алдааг илэрхийлсэн үнэлэмж болж хараахан чадахгүй байна.” гэж дүгнээд “Үзэгдлийн өнгөн тал, хэлбэрийг биш, харин мөн чанар, агуулгыг нээн харуулъя гэвэл түүнийг илэрхийлж чадахуйц шалгуур баримтлах хэрэгтэй болно.”⁵ гэжээ.

Зохиогч Үндсэн хуульт ёсны хөгжлийн асуудлын мөн чанарыг авч үзэхдээ Үндсэн хууль тус бүрийн бүтцэд задлан шинжилгээ хийх, тэдгээрийг зөвхөн “социалист” гэж ижилсэх

⁴ Бүтээлийн 12 дахь тал.

⁵ Бүтээлийн 12-13 дахь тал.

хэлбэрт хамаатуулах нь хангалтгүй болохыг дараа дараагийн дэд бүлгүүдэд тодорхой авч үзэхийн өмнө аливаа түүхийн үйл явцыг үечлэн судлах арга зүйн хувьд нэгд, ямар онол буюу үзэл баримтлалыг удирдлага болгон “ардчилсан”, “ардчилсан бус” гэж, хоёрт, нийгмийн байгууллын ямар үндэс, улс төрийн ямар дэглэм тогтоосныг нь гол шалгуур болгон “социалист маягийн”, “ардчилсан маягийн” гэж тус тус үечлэх нь Үндсэн хуульт ёсны хөгжлийн мөн чанарыг ухааран ойлгоход оновчтой болохыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлажээ.

Зохиогчийн Үндсэн хуульт ёсны хөгжлийн үечлэлийн дээрх үзэл баримтлалыг гүнзгийрүүлсэн судалгаа харьцангуй бага, бүтээлээс ишлэх төдийхнөөр бүтээлч бус хандах, он дарааллаар нь үечлэх хандлага зуршил болсон хэвээр л байгааг нуухын аргагүй.

Дөрөв. Зохиогч 3 дахь дэд бүлэгтээ “Анхдугаар Үндсэн хуулийг онцлон үзэхийн учир”, “1940, 1960 оны Үндсэн хуулийн тухай хэдэн санаа” гэж социалист маягийн Үндсэн хуулийг 2 хэсэгт хуваан авч үзсэн.

Б.Чимид багш бүтээлдээ 1924 оны анхдугаар Үндсэн хуулийг “социалист” гэх ангилалд хамааруулахгүйгээр 1940, 1960 оны Үндсэн хуулиас онцгойлон авч үзсэнийг “энгийн ухамсрын түвшинд нотлон ойлгуулах нь амаргүй”⁶ гэж тодотгосон. Ингэхдээ зохиогч “нэг тогтолцооноос салж, нөгөөд шилжих гэж бий” гэж товч бөгөөд тодорхой дүгнэсэн. Өөрөөр хэлбэл, Дундад зууны үеийн хятад дорно дахины хэв маяг бүхий манжийн эрх зүйн тогтолцоог чиг баримжаагаа болгосон Богд хаант Монгол Улсын эрх зүйн тогтолцоог халж, бидний хувьд урьд өмнө үл мэдэгдэх буюу үзэл баримтлал бүхий эрх зүйн соёлыг нутагшуулах эхлэл болох “XX зуунд колони, хараат байдлаас ангижирсан орнуудын нэг хэсэг нь

⁶ Бүтээлийн 13 дахь тал.

социалист (Зөвлөлт), нөгөө хэсэг нь “хөрөнгөтний” нийгмийн чиг баримжаагаар замнасныг түүх мэднэ. Энэ шалгуураар үзвэл Монгол Улсын анхны Үндсэн хуулийг шууд социалист биш гэхнэ тэр зүгийн чиг баримжаатай хууль гэж ангилахаас аргагүй юм.”⁷

1924 оны Үндсэн хуулийг “социалист чиг баримжаатай хууль” байсныг зохиогч дараах байдлаар хураангуйлан дүгнэжээ. Үүнд:

- “улсынхаа зорилгыг нийгэм журмын чиг баримжаагаар тунхагласан;

- төрийн нийгмийн үндсийг гагцхүү жинхэнэ ардын (ангийн) үүднээс бэхжүүлсэн;

- төрийн төв, орон нутгийн байгууллагын тогтолцоог Зөвлөлүүдийн үзэл санааг удирдлага болгон тодорхойлсон;

- Үндсэн хуулиа Орос-Зөвлөлтийн үндсэн хуулийн агуулгаар болон Коминтерны заавар, шууд оролцоотойгоор боловсруулж, хэлэлцэн баталсан зэрэг нь уг хуулийг социалист чиг баримжаатай (ориентаци) болгожээ”⁸.

Зохиогч анхдугаар Үндсэн хуулийн төслийг боловсруулах, батлах үйл явцад Зөвлөлтийн шууд нөлөөтэй болохыг “уг төслийг хэлэлцэхэд Коминтерны төлөөлөгчид УИХ-ын төлөөлөгч лугаа адил 20 гаруй удаа үг хэлж тайлбарлаж, санал оруулж батлуулан бас хянан найруулах комисст орж ажилласныг “тус” гэж үзэхээсээ илүү бүрэн эрхт улсын дотоод хэрэгт хутгалдан оролцож өөрсдийн үзэл зорилгоо тусгасан гэж дүгнэх нь бодитой болов уу.” гэсэн нь эрх зүй судлаачид төдийгүй нийгэм хүмүүнлэгийн судалгааны үр дүнг хүлээн зөвшөөрсний илэрхийлэл гэж үзүүштэй.

⁷ Бүтээлийн 14 дэх тал.

⁸ Бүтээлийн 14 дэх тал.

Анхны Үндсэн хуулийг “монгол төр улсад түүний гүйцэтгэсэн дэвшилт үүргийг үгүйсгэхэд хүргэж болохгүй” гэсэн нь зохиогч уг хуулийг “социалист чиг баримжаатай хууль” гэж 1940, 1960 оны Үндсэн хуулиас Нэгдүгээрт, түүхэн ач холбогдлыг нь тодотгох, өөрөөр хэлбэл,

- “Монгол Улсынхаа тусгаар тогтнолыг Үндсэн хуулийн хэмжээнд тунхагласнаар түүнийгээ олон улсын “нүдний өмнө барьж” улс төр, эдийн засгийн бүрэн тусгаар байдлын төлөө тэмцэх хууль зүйн үндсийг тавьсан. Хэдийгээр эл зорилгод удтал бүрнээ хүрч чадаагүй ч дараа дараагийн Үндсэн хуульд залгамжлуулан дэлхийн II дайны дараа БНХАУ болон бусад зарим оронд, 1961 онд НҮБ-ын гишүүн болсноор хамтын нийгэмлэгийн гишүүн бүх оронд тус тус бүрэн эрхт тусгаар улс гэдгээ хүлээн зөвшөөрүүлж чадсан юм;

- Хамжлага эзэмшлийн харилцааг үндсээр нь халж хамжлага, шавь ардыг эзний харъяатаас улсын иргэн болгож хүн амын олонхи болох жинхэнэ ардын (иргэдийн) эрх, үүрэг гэдэг цоо шинэ институт бий болгосон (Гэхдээ энэ нь “хүний эрх”-ийн гэсэн үг биш);

- Төрийн захиргааны хаант хэлбэрийг халж, илүү дэвшилттэй Бүгд найрамдах ёсыг тогтоон, Монголын төрийн байгууллагуудын (Их, бага хурал, түүний Тэргүүлэгчид, Засгийн газар, яамд гэсэн) шинэ тогтолцоог бэхжүүлсэн;

- Төрийн байгууламжийн нэгдмэл хэлбэрийг тогтоож, нутгийн захиргааны 5 шатат тогтолцооны (10 гэр, баг, сум, хошуу, аймгийн) үндсийг бэхжүүлсэн;

- Улсын эдийн засгийн суурь, улсын төсвийн орлого, зарлагын тогтолцоог тодорхойлсноороо төрийн эдийн засаг, санхүүгийн үндсийг анхлан тогтоосон;

- Хууль зүйн хувьд БНМАУ-д эх газрын төстэй, Зөвлөлтийн нөлөөтэй эрх зүйн шинэ тогтолцоо бүрдэх суурь нь болж өгсөн зэрэгт түүний гол ач холбогдол оршино.”⁹ гэж анхдугаар Үндсэн хуулийн социалист чиг баримжаатай

Хоёрдугаарт: “түүхээр нэгэнт гэрчлэгдсэн ноцтой сөрөг тал байсныг өгүүлэхээс зайлсхийх ...” шаардлагагүй болсныг зохиогч дараах байдлаар томъёолсон:

- Дэлхийн улсуудын хөгжлийн сонголтын үүднээс үзвэл бусдын эзэгнэл, колоничлолоос гарсан буурай хөгжилтэй орнуудын өмнө ардчилал, зах зээлийн гэх жам ёсны хөгжлийн, эсхүл нийгэм журам гэх гажуудлын ийм 2 зам тулгарсан бөгөөд монголчууд 1924 оны Үндсэн хуулиараа сүүлчийн замыг сонгосон нь төөрөгдөл болжээ;

- Хэдийгээр төрийн захиргааны өмнөхөөс илүү, орчин цагийн БНУ-ын хэлбэрийг сонгосон хэдий ч түүнийг хэрэгжүүлдэг засаг төрийн байгууллагын төвлөрсөн тогтолцоог бэхжүүлсэн байв. Үүнийг цаг үеийн шаардлага мэтээр тайлж болох талтай боловч тэр нь чинагшид залгамжлагдан чангарснаараа гажуудалд хүргэжээ.

Уул нь Үндсэн хууль бол урсгал байдал буюу “цаг үеийн шаардлага”-д үл захирагдах учиртай;

- Төрийн байгууллын нийгэмшлийн үндсийг “большевик” маягаар сонгож пролетари буюу эсхүл “ажилчин, тариачин” хэмээсний оронд “жинхэнэ ард” гэж хүн амын асар олонхийн хамгийн ядуулаг хэсгийг засгийн эрхийн эх үүсвэр болгосон байна.¹⁰

⁹ Бүтээлийн 17-18 дахь тал.

¹⁰ Бүтээлийн 19 дэх тал.

Зохиогчийн “Социалист маягийн Үндсэн хуулийн тухай” дэд бүлгийн эхний хэсэгтээ “Анхны Үндсэн хуулийг онцлон үзэхийн учир” гэх хэсэгт хэдийгээр гажсан ч гэсэн “эх газрын төстэй, Зөвлөлтийн нөлөөтэй эрх зүйн шинэ тогтолцоо бүрдэх суурь нь” тавигдсан нь БНМАУ-д түүхийн үнэ цэнэтэй үйл явдал байсныг тодотгохдоо “авч гээхийн ухаан”-аар хандах, нөгөө талаар ялангуяа анхдугаар Үндсэн хуулийг батлах хүртэлх хугацаанд эрх бүхий байгууллагаас Үндсэн хуулийн шинжтэй цөөнгүй дүрэм, тогтоол гарган төр улсаа төвхнүүлж, Үндсэн хуулийн шинэ ухамсар бүрэлдэхэд бодитой нөлөөлсөн болохыг түүхэн баримтад үндэслэн дүгнэсэн.¹¹

Монголын эрх зүйн түүхийн судалгаанд анхдугаар Үндсэн хууль батлахаас өмнөх буюу 1921-1924 оны хооронд эрх бүхий байгууллагаас батлагдсан “Үндсэн хуулийн шинж чанартай эрх зүйн акт”-уудад ач холбогдол өгч байсан бол зохиогч “Үндсэн хуулийн шинжтэй цөөнгүй дүрэм, тогтоол гарган төр улсаа төвхнүүлж анхны Үндсэн хуулиар Бүгд Найрамдах засгийг бэхжүүлэх хууль зүйн нөхцөл бүрдүүлсэн байдаг.”¹² гэснээс “хууль зүйн нөхцөл бүрдүүлсэн” гэдгийн гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

- Социалист маягийн 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудаас 1924 оны Үндсэн хуулийг тусад нь “социалист чиг баримжаатай” гэж тусад нь авч үзсэнийг зохиогчийн “энгийн ухамсрын түвшинд нотлон ойлгуулах нь амаргүй” гэснийг эргэцүүлэх зайлшгүй шаардлага байна. Монголчууд 1900-аад оны эхэн үеэс дэлхийн эрх зүйн соёлтой танилцан тухайн үеийн Үндсэн

¹¹ Үндсэн хууль батлахын ямар Монгол Улс нь 1921-1924 онд “Монгол Улсын Ардын Засгийн газрын Хурлын түр зуурын дүрэм” (1921.09.12); “Улсын түр цагийн хурлын дүрэм” (1921.09.20); “Тангаргийн гэрээ дүрэм” (1921.11.01); “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм” (1921.03.05); “Бүгд Найрамдах засаг тогтоон явуулах тухай Ардын Засгийн газрын тогтоол” (1924.06.13); Монгол Улсын “Улсын Их Хурлын дүрэм” (1924.09.19) гэх зэрэг Үндсэн хуулийн шинжтэй цөөнгүй дүрэм, тогтоол гарган төр улсаа төвхнүүлж анхны Үндсэн хуулиар Бүгд Найрамдах засгийг бэхжүүлэх хууль зүйн нөхцөл бүрдүүлсэн байдаг. Бүтээлийн 16 дахь тал.

¹² Бүтээлийн 16 дахь тал.

хуульт байгуулалттай хэд хэдэн орны Үндсэн хуулийг орчуулан судалсан байдгийг, мөн эрх зүйн судалгааны сонгомол зохиол бүтээлүүдтэй танилцсан болохыг зохиогч бусад бүтээлүүддээ авч үзсэн байдаг бөгөөд түүний энэхүү онолын судалгаанд үндэслэн “энгийн ухамсрын түвшинд нотлон ойлгуулах” үүргийг бидэнд үлдээсэн хэрэг.

- Анхдугаар Үндсэн хууль батлахаас өмнөх улс төрийн нөхцөл байдал, Үндсэн хуулийн төслийн хувилбарууд, мөн хөгжилтэй орнуудын төрийн эрх зүйн талаар тоймчилсон судалгаа хийж “Улсын эрх” гэдэг судалгааны тайлан болон Үндэсний ардчилсан үзэл санаатай хүмүүсийн туурвисан эрдэм судлалын бүтээлүүдийг дурдсан нь шинэ цагийн эрх зүйн шинжлэх ухааны судалгааны үндэс тавигдсаныг онцолсон юм.

Тав. 1992 оны Үндсэн хуулийг боловсруулахдаа олон улсын жишиг хандлага, үндэсний эрх зүйн хөгжлийн харилцан хамаарал, нийгмийн шилжилтийн үе дэх Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт, уг зохицуулалтын нийгэм, улс төр, эдийн засгийн байгуулалтад хэрхэн нөлөөлсөн зэрэг асуудлыг хөндсөн нь энэ чиглэлээр туурвисан бүтээлүүдээс онцлог юм.

Бүтээлийн 1 дүгээр бүлгийн 4 дэх дэд бүлгийг “1992 оны Үндсэн хууль бол шинэ маягийн Үндсэн хууль” гэж тодотгон авч үзэхдээ Монгол Улсын өмнөх гурван Үндсэн хуулиас үзэл баримтлалын хувьд ялгаатай болохыг:

1. Монгол оронд ямар нэгэн нийгэм байгуулах, түүнээс өөр нийгэмд шилжих гэхчлэн стратегийн зорилгыг тодорхойлоогүй буюу хөтөлбөрийн шинж агуулаагүй;

2. нийгмийн байгууллын эзэн болсон хүний эрх чөлөөт байдал, бүх нийгмийн оршин хөгжих үндэс буюу яс, булчингийн тогтолцоог бэхжүүлж хамгаалдаг болохоос биш, улс орны

хөгжлийг хөтөлбөржүүлдэг ээлжит арга хэмжээний төлөвлөгөө, удирдамж биш гэдгийг харьцуулан шинжилж, нэгтгэн дүгнэсэн.¹³

Монгол Улсын эрх зүй харилцан хамааралтайгаар хөгжиж, ялангуяа Үндсэн хуулиуд нь түүхэн цаг үеийн үүргийг ямар нэгэн хэмжээгээр гүйцэтгэсэн гэдгийг нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралд гарсан өөрчлөлт, хувьсалыг эерэг болон сөрөг үр дагавартайгаар нь авч үзсэнээрээ шинжлэх ухааны ач холбогдолтой болно.

Монгол Улсын эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийг дахин үнэлсэн, цаашид эрх зүйн бүтээх үйл ажиллагааны үндсэн зарчмыг томъёолж, түүхийн эх сурвалжийг агуулгын түвшинд хэрхэн задлан шинжилж, нэгтгэн дүгнэж болдгийг, мөн дараа дараагийн судалгааны объект юу байж болохыг тус тус түүчээлэн үлдээснээрээ практик ач холбогдолтой юм.

Мөн зохиогч бүтээлдээ “хууль тогтвортой даргалах” онол, арга зүйн үндсийг олон улсын жишиг хандлага, туршлагыг үндэс болгон:

1) сонгосон зам, түүнд тохируулах гэсэн “нийгмийн байгуулал”, улс төрийн дэглэмээс;

2) үндсэн хуулийн хэв маяг буюу ямар үзэл баримтлалд тулгуурласнаас;

3) тухайн орны нийгмийн ухамсар, ялангуяа улс төр, эрх зүйн ухамсар соёлын түвшингээс;

4) засаг төр барих арга ухаан, улс төрийн тууштай байдал, залгамжлал, тэвчээрээс ихээхэн шалтгаалдаг бололтой.¹⁴ гэж дүгнэн өгүүлснийг эрх зүйн шинжлэх ухааны судалгааны институт анхааралдаа авах нь зүйн хэрэг.

¹³ Бүтээлийн 31 дэх тал.

¹⁴ Бүтээлийн 32-33 дахь тал.

ДҮГНЭЛТ

- Бяраагийн Чимид багш Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэг “улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго” болгон, үүний тул бүтээлийнхээ агуулгаар Үндсэн хуулийн эрхэм зорилгыг бүрэн шингээн туурвисан байна.

- Бяраагийн Чимид багшийн “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” (ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил) бүтээлийн “Үндсэн хуулийн хөгжлийг шинэ хандлагаар судлах нь” нэгдүгээр бүлэг нь Монгол Улсын эрх зүйн шинжлэх ухааны суурь судалгааны бүтээл төдийгүй шинэ цагийн эрх зүйн соёл, ухамсар төлөвших үйл явцын эхлэл, өрнөлийг нэгтгэн авч үзсэнээрээ онолын болон практик ач холбогдолтой юм.

- Бүтээлийн нэгдүгээр бүлгийг бусад бүлэгтэй харьцуулбал, Үндсэн хуулийн хөгжлийн асуудлаар төлөөлүүлэн эрх зүйн шинжлэх ухааны онол, арга зүй хандлагыг шинэтгэх ямар боломж, бололцоо байгааг тодорхой сэдвүүдээр задлан шинжилж, нэгтгэн дүгнэсэн бөгөөд системийн онол, арга зүйгээр илэрхийлсэн байна.

- Зохиогч энэхүү бүтээлдээ шинэ цагийн эрх зүйн соёл хэрхэн төлөвшсөн болохыг Монгол Улсын Үндсэн хуулиудаар төлөөлүүлэн авч үзэхдээ тэдгээрийн хувьсал, өөрчлөлтийг эрх зүйн онол, арга зүйн түвшинд харьцуулан судалж, нэгтгэн дүгнэсэн байна.

- Энэхүү дэд бүлгийн агуулгад эрх зүй судлалд онол, арга зүйг шинэтгэхэд учир буй мэргэшсэн бус хандлага давамгайлж тэр

хэмжээгээр өмнөхийн нэгэн адил хоёр туйлд хэт автах хандлага, айдас буйг анхааруулсан төдийгүй тэр хэмжээгээр Үндэсний эрх зүйд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэдгийг зохиогч бүтээлдээ хэд хэдэн удаа дурдсаныг дараа дараагийн судлаачдад сургамж болгон үдээжээ.

- Зохиогч энэхүү бүтээлээ нэгдүгээрт, Үндсэн хуулийг шинжлэх ухааны түвшинд нарийвчлан судлахад, хоёрдугаарт, сонирхогчдод зориулсан нь бүтээлийн бичвэр, өгүүлбэрийн бүтэц, үгийн сонголт зэргээс тодорхой харагдана. Энэхүү зорилт нь Үндсэн хуульт ёсны хөгжлийг академик төдийгүй энгийн ухамсрын төвшинд Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах нь улс үндэстний оршихуйн язгуур үндсийг ухааран мэдэх шаардлагыг бүрнээ илэрхийлэн шингээсэн бүтээл юм.

- Бүтээлийн нэгдүгээр бүлэг төдийгүй уг бүтээл нь судлаачдад эрх зүйн шинжлэх ухааны онол, арга зүйн үндэслэл бүхий дүгнэлтийг хэрхэн боловсруулах, судалгааны ажил ямар байх ёстойг бүхий л талаар үлгэрлэсэн томоохон бүтээл гэдэгтэй санал нийлнэ гэдэгт огт эргэлзэхгүй байна.

- Зохиогч “хөвөн боосон чулуу” гэдэг шиг эрх зүйн шинжлэх ухааны арга зүй, арга, хандлага нь хэр шинэчлэгдэж вэ? гэдэгт сэтгэл ханах болоогүй гэдгийг хойч үеийнхэнд сануулсан нь багшийн сэтгэлийн эмзэглэл, төдийгүй “бид шинжлэл судлалынхаа хуучин хандлага, аргаас төдий л зоригтой салж, олигтой холдож чадаагүй, айдас хүйдсээс ч бас бүрэн ангижраагүй, өнгөрснөө давтсаар байгаагаа нуухын хэрэг огт үгүй. “Даравч дардайна, булавч бултайна” гэдэг билээ.” гэснийг дүгнэлт хэсэгт багшийн дүгнэлтийг тоть мэт давтан уншигчийн хувьд өөртөө болон бусад судлаачдад уг үгийг нь дахин дахин хүргэхийг хүслээ.